



2026 он 09 сар 18 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15 дахь заалт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн охин компани болох Говь Кашмер Казахстан ХХН-ийн үйл ажиллагааг эхлүүлэх, тасралтгүй байдлыг хангах зорилгоор 2026 онд тус охин компанид бүтээгдэхүүн нийлүүлэх “Худалдах, худалдан авах гэрээ”-г зах зээлийн үнэ, нөхцөлөөр байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан гэрээг байгуулахтай холбогдуулан гэрээний нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, гэрээ болон түүнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтөд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Говь ХК-ийн Гадаад борлуулалт хариуцсан захирал (Г.Анударь), Говь Кашмер Казахстан ХХН-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан) нарт тус тус олгосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах тул уг хэлцлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонирхлын зөрчилгүй, хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
4. Энэхүү тогтоолын хүрээнд Говь Кашмер Казахстан ХХН-тай байгуулсан “Худалдах, худалдан авах гэрээ”-ний хэрэгжилт, гүйцэтгэлийн мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны ээлжит хуралд тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР